







КРАНЫ ЗАМ ХӨНДЛӨН БА ДАГУУДАА ХАЗАЙХ ХЯЗГААРЫН ХЭМЖЭЭ БУЮУ ЗӨВШӨӨРӨГДӨХ ХҮЛЦЭЛ

Зөрүү, мм	Зургаар үзүүлэхэд	Кран			
		Гүүрэн	Цамхагт	Вандан	Арлан
Нэг хөндлөн огтлол дахь зам төмрийн толгойн зөрүү, P1 мм S- царигийн хэмжээ (алслалт)		40	45-60	40	40
Зэргэлдээ тулгуур дахь зам төмрийн зөрүү, P2 мм		10	-	-	-
Зам төмрийн царигийн хэмжээний өргөсөлт эсвэл нарийсалт (алслалтын зайн хэмжээний өөрчлөлт), P2 мм		15	10	15	15
Зам төмөр залгагдах хэсэг дэх өндрийн зайн хэмжээний зөрүү, P4 мм		2	3	2	2
Зам төмөр залгагдах хэсгийн завсрын зайн хэмжээний зөрүү, P5 мм /орчны температур 0, зам төмөр 10м урттай үед/		6			
Краны зам 10м тутамд зам төмрийн толгойн зөрүү, P6 мм		-	40	30	20

Тайлбар:

- Краны нийт замын 5м тутамд P1 ба P2 зайн зөрүүг хэмжинэ.
- Орчны дулаан 10С хэмээр өөрчлөгдөх тутамд завсрын P5 зай 1.5 мм-ээр өөрчлөгдөнө. Жишээ нь: +20С хэмийн дулаанд зам төмөр хоорондын завсрын зай 3мм, харин -10С хэмийн хүйтэнд зам төмөр хоорондын завсрын зай 7.5мм байна.

КРАНЫ ЗАМ ТӨМӨРТ ГОЛОГДОЛД ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТ

Краны зам төмөрт дараах гэмтэл, согог илэрсэн үед гологдолд тооцно. Үүнд:

- Бүх төрлийн хэмжээтэй ан цав
- Зам төмрийн толгой босоо, хэвтээ эсвэл хавсарсан (босоо мөн хэвтээгийн хагас) чиглэлд анхны хэмжээнээс 15%-иас их элэгдсэн.

Краны замын дэрэнд дараах гэмтэл, согог илэрсэн үед гологдолд тооцно. Үүнд:


- Төмөр бетон дэрний арматур төмөр ил гарч бетон хагарсан эсвэл 250 мм-ээс урт хэсэгт бетон хугарсан

- Төмөр бетон дэр нэвт хугарсан эсвэл өргөн нь 0.3 мм, урт нь 100 мм-ээс их хөндлөн цууралт үүссэн
- Модон дэрэнд хугаралт эсвэл гүн нь 50 мм, урт нь 200 мм-ээс их хөндлөн цууралт үүссэн. Илжрэлтийн гадаргуу, ивүүрийн дор 20мм-ээс, бусад хэсэгт 60 мм-ээс их хэмжээтэй үүссэн.

Дүүжин цахилгаан таль, тэргэнцэрийн зам төмөрт /монорельс/ дараах гэмтэл, согог илэрсэн үед гологдолд тооцно. Үүнд:

- Бүх төрлийн хэмжээтэй ан цав
- Зам төмрийн суурийн тавцангийн өргөний элэгдэл, $\Delta B \geq 0.05B$ /зурагт үзүүлэв/
- Зам төмрийн суурийн тавцангийн зузааны элэгдэл, $\Delta \delta \geq 0.2 \delta$, мөн түүний үзүүрийн муруйлтын хэмжээ, $f_1 \leq 0.1 \delta$ байвал /зурагт үзүүлэв/

Зам төмрийн суурийн тавцангийн элэгдэл, түүний үзүүрийн муруйлтыг хэмжиж, оношлох бүдүүвч зураг:



- B- тавцангийн өргөний анхны хэмжээ
- ΔB- тавцангийн элэгдэл
- t- хананы зузаан
- f1- тавцангийн үзүүрийн муруйлтын хэмжээ
- δ- тавцангийн үзүүрээс $(B-t)/4$ зайд байх, түүний анхны зузааны хэмжээ
- Δδ- тавцанд элэгдлээс шалтгаалж үүссэн хэмжээ